



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Алтай хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа  
Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг  
Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Цэрэнханд  
Утас: 99086371 Цахим хаяг: [tserenkhandd@audit.gov.mn](mailto:tserenkhandd@audit.gov.mn)  
Аудитор: Б.Батбаатар  
Утас: 89593311 Цахим хаяг: [batbaatarb@audit.gov.mn](mailto:batbaatarb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 142

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шарга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шарга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 25.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн, үйл ажиллагааны орлого 0.4 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 0.1 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1.1 сая төгрөгөөр тус тус тасарсан, батлагдсан төсвөөс төсөвт байгууллагуудад санхүүжилтийг олгохдоо 35.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон, нийт 63.2 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Шарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 18 дугаар тогтоолын 1 дэх заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 дугаар тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг хүргүүлжээ.

0702900461

## **Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны зардлын нийт гүйцэтгэл өмнөх оноос 210.1 сая төгрөг буюу 12.8 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 8 хөтөлбөр 21 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 15 арга хэмжээг бүрэн, 7 арга хэмжээг 85.0 хувь буюу нийт дүнгээр 98.5 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 96.0 хувиар дүгнэсэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**/мянган төгрөг/**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	451,956.1	529,127.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,594,429.3	9,664,029.7
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,046,385.4</b>	<b>10,193,157.6</b>
Нийт өр төлбөрийн дүн	250.0	11,008.8
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,046,135.4	10,182,148.8
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,046,385.4</b>	<b>10,193,157.6</b>
Үйл ажиллагааны орлогын дүн	2,800,195.8	9,759,388.0
Үйл ажиллагааны зардлын дүн	2,010,672.0	1,401,924.9
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>789,523.8</b>	<b>8,357,463.1</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	2,961,756.8	221,699.8
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(2,172,232.9)</b>	<b>8,135,763.4</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,218,368.4	2,046,135.4
Тайлант оны үр дүн	(2,172,232.9)	8,135,763.4
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,046,135.4</b>	<b>10,182,148.8</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,189,359.7	1,478,386.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,911,565.4	1,200,953.1
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>277,794.3</b>	<b>277,433.7</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(180,217.5)</b>	<b>(241,281.8)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>0.0</b>	<b>(66,287.6)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>97,576.8</b>	<b>(30,135.8)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	141,775.2	239,351.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	239,351.9	209,216.2

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 162,893.3 мянган төгрөгийн 8 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 63,284.2 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлснээс, 16,390.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 45,406.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, 1,486.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.


Залруулагдаагүй зөрчлийн дүн 63,284.2 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 32,700.0 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

**5.1.1 Харьяа байгууллагууд**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

5.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил



Аудитаар 69,160.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдээр 16,390.4 мянган төгрөгийн үндсэн зээлийг хуваарьт хугацаанд төлөөгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

5.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар 93,490.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 8,063.4 мянган төгрөгийн 3 зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1,486.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар мөнгөн гүйлгээний тайланд 242.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 37,343.5 мянган төгрөгийн 3 зөрчил илрүүлж, 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

5.2.1 Албан шаардлага

1. Үйл ажиллагааны орлого 425.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 131.8 мянган төгрөгөөр, түрээсийн орлого 1,120.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Шарга Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 24 дүгээр тогтоол", заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр ханган ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Батлагдсан төсвөөс төсөвт байгууллагуудад санхүүжилтийг олгохдоо Засаг даргын тамгын газарт 22,300.0 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн санд 13,366.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Шарга Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 24 дүгээр тогтоол, заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн дагуу төсвийн олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 29,940.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, 16,390.4 мянган төгрөгийн зөрчлийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8,063.4 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 1,486.9 мянган төгрөгийн зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.



Шарга сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	9	63,284.2	1	16,390.4	6	45,406.9	2	1,486.9	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/								
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шарга сумын Засаг даргын тамгын газар	1	19,880.0	-	-	1	19,880.0	-	-
Дүн	1	19,880.0	-	-	1	19,880.0	-	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн ангилал	захирагчийн	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
			Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
3	4	5								
A	1		2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ		1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ		1	1	-	-	-	1	-	-